



БАЯНХОНГОР АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

310 дугаар байр, Лувсанданзанжанцангийн
өргөн чөлөө 3 дугаар гудамж, Номгон 1 дүгээр баг,
Баянхонгор сум, Баянхонгор аймаг, 64101
Утас: (976) 70442584

Цахим шуудан: procurement.bayankhongor@audit.gov.mn

2025.02.25 № 1/182
танай _____ -ны № _____ -т

Г БУУЦАГААН СУМЫН ХҮҮХДИЙН Г ЦЭЦЭРЛЭГИЙН ЭРХЛЭГЧ Д.ГЭРЛЭЭ Г ТАНАА

Тус байгууллагын 2024 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан, дүгнэлт, албан шаардлага, төлбөрийн акт хүргүүлж байна.

Албан шаардлага, төлбөрийн актын биелэлтийг нотлох баримтын хамт 2025 оны 05 дугаар сарын 15-ны ирүүлнэ үү.

Хавсралт *06*...хуудастай.

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ
АУДИТОР *[Signature]* Б.МӨНХБАТ



006425030288



САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Бууцагаан сумын Цэцэрлэгийн 2024 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан

Аудитын код: БНА-2025/181/НА-СТА-ТШЗ

Цахим хуудас:
www.audit.mn

Баянхонгор хот

2025 оны 02 дугаар сар 19

Баянхонгор аймаг дахь Төрийн аудитын газрын
Дарга, тэргүүлэх аудитор Б.Мөнхбат
Утас: 70442584 Цахим хаяг: munkhbatb@audit.gov.mn
Аудитын менежер М.Алтантуяа
Утас: 80112188 Цахим хаяг: altantuyam@audit.gov.mn
Аудитыг гэрээгээр гүйцэтгэсэн: Номгон аудит ХХК
Захирал Г.Саранчимэг
Утас: 89891034 Цахим хаяг: audit.nomgon@gmail.com
Аудитор:: О.Мандах
Утас: 89010203 Цахим хаяг: audit.nomgon@gmail.com

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.

АГУУЛГА

1.ХАРААТ БУС АУДИТОРЫН ДҮГНЭЛТ	3
2.АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛ	9
3. САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТОДРУУЛГА.....	15
4. АУДИТЫН ТАЙЛАН	18
4.1 Ерөнхий зүйл	18
4.2 Материаллаг байдал	19
4.3 Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилт	19
4.4 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал ...	19
4.4.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт.....	19
4.4.2 Худалдан авах ажиллагааны талаар.....	20
4.5 Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт	20
4.5.1 Завсрын аудитын талаар.....	20
4.5.2 Өмнөх аудитын мөрөөр авч хэрэгжүүлсэн арга хэмжээний үр дүн.....	20
4.6 Дараагийн аудитаар анхаарах асуудал	21
5. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ	21
5.1 Төлбөрийн акт	21
5.2 Албан шаардлага	22
6. Аудитаар илэрсэн алдаа, зөрчлийн нэгтгэл.....	23

Товчилсон үгийн жагсаалт

УСНББОУС	Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт
АДБОУС	Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт
БШУС	Боловсрол, шинжлэх ухааны сайд
ИТХ	Иргэдийн төлөөлөгчдийн хурал
СТСХ	Санхүү, төрийн сангийн хэлтэс
НБББББ	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг
ХХОАТ	Хувь хүний орлогын албан татвар



**БАЯНХОНГОР АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР**

310 дугаар байр, Лувсанданзанжанцангийн
өргөн чөлөө 3 дугаар гудамж, Номгон 1 дүгээр баг,
Баянхонгор сум, Баянхонгор аймаг, 64101
Утас: (976) 70442584

Цахим шуудан: procurement.bayankhongor@audit.gov.mn

2025.02.15 № 2/22
танай _____-ны № _____-т

Хязгаарлалттай дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Бууцагаан сумын Цэцэрлэгийн 2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Бидний үзэж байгаагаар Хязгаарлалттай санал дүгнэлтийн үндэслэл хэсэгт тайлбарласан зүйлсийн үр нөлөөг эс тооцвол 2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, тайлант жилийн эцсээрх тэдгээрийн санхүүгийн үр дүн, мөнгөн гүйлгээ, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу бүхий л материаллаг байдлын үүднээс үнэн зөв толилуулсан байна.

Хязгаарлалттай санал дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, аудит хийгдэх байгууллагаас хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой аудитын нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

Санхүүгийн тайлангийн аудитаар илэрсэн дараах зөрчлүүд нь гүйцэтгэлийн нэмэлт урамшууллаас 843.8 мянган төгрөгийн ХХОАТ суутган тооцоо хийгээгүй, цалингийн зардлаас 2,582.0 мянган төгрөгийн бичиг хэргийн материал авч бүлэг хооронд гүйлгэн зориулалт бусаар зарцуулсан, хүүхдийн хоолны материалыг гэрээний үнийн дүнгээс 3,573.0 мянган төгрөгөөр илүү олгосон, амралтын цалингаас нийгмийн даатгалын шимтгэлийн тайлан, ХХОАТ-ын тайланд мэдээлээгүй зэрэг 11,229.7 мянган төгрөгийг зөрчлүүд нь бидний тогтоосон материаллаг байдлын түвшнээс давсан бөгөөд дангаар буюу нийт дүнгээрээ санхүүгийн тайланд материаллаг нөлөөтэй боловч өргөн тархаагүй байна.

5020224

Дээрх зөрчлүүд нь ХХОАТ-ын тухай хуулийн 7 дугаар зүйлийн 7.1¹, Нийгмийн даатгалын тухай хуулийн 21.1², Засгийн газрын 2024 оны 01 дүгээр сарын 25-ны өдрийн "Хувьсах зардлын хэмжээ, итгэлцүүр, журам батлах тухай" 39 дүгээр тогтоол "Сургуулийн өмнөх болон ерөнхий боловсролын нэг суралцагчид ногдох хувьсах зардлын хэмжээний бүрэлдэхүүн, зардлын зориулалт, эдийн засгийн ангиллын дэлгэрэнгүй заавар", БШУ-ны сайд, Эрүүл мэндийн сайдын хамтарсан тушаал 2022 оны 06.29 -ны өдрийн Багшийн эрүүл мэндийн талаар авах зарим арга хэмжээний тухай А/232, А/340 дугаар тушаалын 2.2 дах заалт, Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.2.5."дансны өглөг, авлага ба төлбөрийн тооцоог хянах, ажил, гүйлгээг гарахаас нь өмнө хянан, баталгаажуулах" гэсэн заалтыг хэрэгжүүлээгүй, "үнэн зөв байх", "оршин байх., "нийцсэн бөгөөд зохистой байх" гэсэн батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Асуудлыг онцолсон хэсэг

Байгууллага үйл ажиллагаагаа тасралтгүй явуулахтай холбоотой тодорхой бус байдал үүсээгүй, 2024 онд 1,265,919.5 мянган төгрөгийн санхүүжилт батлагдсанаас гүйцэтгэлээр 1,145,098.6 мянган төгрөгийг зарцуулж, орон нутгийн төсөвт 2,803.7 мянган төгрөгийг төвлөрүүлж, оны эцэст харилцах дансанд 117,441.3 мянган төгрөгийн үлдэгдэлтэй гарчээ.

2024 оны байгууллагын гүйцэтгэлийн үнэлгээгээр улсын хэмжээнд 3-р түвшинд үнэлэгдэн 12,981.9 мянган төгрөгийн гүйцэтгэлийн урамшуулал авч, багшийн гүйцэтгэлийн үнэлгээнд 10 багш шалгагдан 7 багш 1-4 дүгээр түвшинд үнэлэгдэн 15-40 хувийн үр дүнгийн мөнгөн урамшууллыг сар бүр авсан байна.

Аудитын гол асуудал

Аудитын гол асуудал гэдэг нь тайлант үеийн санхүүгийн тайлангийн аудитад хамгийн чухал нөлөөтэй хэмээн мэргэжлийн шүүн тунгаалтаар бидний авч үзсэн асуудал байна. Гол асуудлыг санхүүгийн тайлангийн аудитын хүрээнд бүхэлд нь харгалзаж, аудитын санал дүгнэлтээ илэрхийлэхэд авч үзсэн бөгөөд энэхүү гол асуудлын талаар бид тусад нь дүгнэлт гаргахгүй.

Бусад асуудлын хэсэг

Байгууллагын удирдлага бусад мэдээлэлтэй холбоотой үүрэг хариуцлагыг хүлээх Бууцагаан сумын Цэцэрлэгийн 2024 оны гүйцэтгэлийн төлөвлөгөөнд 4 үндсэн зорилт, 49 арга хэмжээг хэрэгжүүлэхээр тусгаж, гүйцэтгэлийн төлөвлөгөөний биелэлтийг 96.0 хувьтай тайлагнасныг 93.3 хувьтай дээд шатны байгууллагаас дүгнэсэн байна.

Бууцагаан сумын Цэцэрлэгийн 2024 оны санхүүгийн тайланд толилуулаагүй, тодруулаагүй асуудал байхгүй.

Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага

¹ Албан татвар төлөгчийн цалин, хөдөлмөрийн хөлс, шагнал, урамшуулал болон тэдгээртэй адилтгах хөдөлмөр эрхлэлтийн орлогод дараах орлогыг хамруулна

² Ажил олгогч даатгуулагчийн цалин хөлс, түүнтэй адилтгах орлогоос нийгмийн даатгалын шимтгэлийг сар бүр тооцон суутгаж, ажил олгогчийн цалин хөлсний сан, түүнтэй адилтгах орлогоос тооцсон шимтгэлийн хамт тухайн сард баггаан нийгмийн даатгалын санд төлнө

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүх материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гарах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ
АУДИТОР

Б.МӨНХБАТ



2.АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛ

2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

/төгрөгөөр/

Дансны код	Балансын үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл
1	ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН	193,037,735.98	254,765,238.21
31	МӨНГӨН ХӨРӨНГӨ	106,567,462.15	117,441,356.44
312	Банкинд байгаа бэлэн мөнгө	106,567,462.15	117,441,356.44
3121	Төгрөг	106,567,462.15	117,441,356.44
31211	Төрийн сангийн харилцах	106,567,462.15	117,441,356.44
35	БАРАА МАТЕРИАЛ	86,470,273.83	137,323,881.77
354	Хангамжийн материал	86,470,273.83	137,323,881.77
35410	Бичиг хэргийн материал	699,600.00	699,600.00
35420	Аж ахуйн материал	25,032,869.28	21,392,071.63
35460	Хүнсний материал	835,680.00	20,000.00
35470	Бусад хангамжийн материал	59,902,124.55	115,212,210.14
2	ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН	1,787,765,608.23	1,760,101,876.37
39	ҮНДСЭН ХӨРӨНГӨ	1,787,765,608.23	1,760,101,876.37
392	Биет хөрөнгө	1,758,365,608.23	1,730,701,876.37
39201	Барилга, байгууламж, орон сууц	1,870,381,859.76	1,870,381,859.76
39202	Хуримтлагдсан элэгдэл	-200,157,365.64	-263,310,570.96
39205	Машин тоног төхөөрөмж (компьютер)	104,551,789.75	147,119,944.75
39206	Хуримтлагдсан элэгдэл	-53,354,330.54	-70,950,492.24
39207	Тавилга, аж ахуйн эд хогшил	54,410,453.80	72,167,297.80
39208	Хуримтлагдсан элэгдэл	-20,959,497.90	-28,198,861.74
39217	Ном	3,492,699.00	3,492,699.00
393	Биет бус хөрөнгө	29,400,000.00	29,400,000.00
39301	Програм хангамж	150,000.00	150,000.00
39302	Хуримтлагдсан элэгдэл	-150,000.00	-150,000.00
39303	Бусад биет бус хөрөнгө	29,400,000.00	29,400,000.00
3	НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II	1,980,803,344.21	2,014,867,114.58
4	НИЙТ ӨР ТӨЛБӨР	00.00	13,055,100.00
41	БОГИНО ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР	00.00	13,055,100.00
413	Өглөг	00.00	13,055,100.00
41310	Ажилчидтай холбогдсон өглөг	00.00	2,582,000.00
4136	Бусад өглөг	00.00	10,473,100.00
41361	Байгууллагад төлөх өглөг	00.00	10,473,100.00
5	ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН	1,980,803,344.21	2,001,812,014.58
51	Засгийн газрын хувь оролцоо	1,980,803,344.21	2,001,812,014.58
511	Засгийн газрын оруулсан капитал /Засгийн газрын сан/ орон нутгийн сан	118,876,104.00	118,876,104.00
51101	Өмч: - төрийн	118,876,104.00	118,876,104.00
512	Хуримтлагдсан үр дүн	1,643,430,453.81	1,664,439,124.18
51210	Өмнөх үеийн үр дүн	1,643,430,453.81	1,643,430,453.81
51220	Тайлант үеийн үр дүн	00.00	21,008,670.37
51300	Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү	218,496,786.40	218,496,786.40
6	ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V	1,980,803,344.21	2,014,867,114.58

2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан

/Төгрөгөөр/

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)	1,544,039,815.50	1,254,145,284.59
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	731,141,615.50	94,874,084.59
120	Нийтлэг татварын бус орлого	731,141,615.50	94,874,084.59
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого	17,344.00	105,000.00
1200041	Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих	00.00	00.00
1200042	Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих	17,344.00	105,000.00
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	812,898,200.00	1,159,271,200.00
1310	Улсын төвлөрсөн төсвөөс	740,209,600.00	1,052,582,900.00
131001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт	740,209,600.00	1,052,582,900.00
1320	Орон нутгийн төсвөөс санхүүжих	72,688,600.00	106,688,300.00
132001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/	72,688,600.00	106,688,300.00
2	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН	757,645,557.48	1,233,136,614.22
21	УРСГАЛ ЗАРДАЛ	757,645,557.48	1,233,136,614.22
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	739,489,369.20	1,221,894,749.78
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	456,419,241.12	799,121,706.18
210101	Үндсэн цалин	456,185,561.12	799,121,706.18
210102	Нэмэгдэл	233,680.00	
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	57,819,162.97	99,033,404.53
210201	Тэтгэврийн даатгал	38,275,585.94	67,412,669.89
210202	Тэтгэмжийн даатгал	4,864,358.94	7,805,390.50
210203	ҮОМШО-ний даатгал	3,899,547.17	4,301,244.61
210204	Ажилгүйдлийн даатгал	969,344.35	3,864,228.10
210205	Эрүүл мэндийн даатгал	9,810,326.57	15,649,871.43
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	57,073,152.19	100,884,635.56
210301	Гэрэл, цахилгаан	8,816,412.19	11,087,099.56
210302	Түлш, халаалт	46,456,740.00	88,147,536.00
210303	Цэвэр, бохир ус	1,800,000.00	1,650,000.00
2104	Хангамж, бараа материалын зардал	7,312,020.00	00.00
210401	Бичиг хэрэг	2,988,900.00	00.00
210402	Тээвэр, шатахуун	3,612,500.00	00.00
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	240,000.00	00.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	470,620.00	00.00
2105	Нормативт зардал	90,087,525.00	100,905,475.00
210502	Хоол, хүнс	90,087,525.00	100,905,475.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	921,000.00	3,044,600.00
210604	Урсгал засвар	921,000.00	3,044,600.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	1,148,100.00	2,728,900.00

Бууцагаан сумын Цэцэрлэгийн 2024 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайлан


210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	00.00	142,800.00
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	00.00	800,000.00
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	1,148,100.00	1,786,100.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	68,709,167.92	116,176,028.51
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	10,326,780.00	20,370,697.65
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	120,000.00	7,816,600.00
210903	Үндсэн хөрөнгийн элэгдэл, хорогдол	58,262,387.92	87,988,730.86
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	18,156,188.28	11,241,864.44
2132	Бусад урсгал шилжүүлэг	4,121,500.00	8,438,200.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	4,121,500.00	8,438,200.00
2134	Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдал олгох татаас, санхүүжилт	14,034,688.28	2,803,664.44
213403	Товлорүүлэх шилжүүлэг	14,034,688.28	2,803,664.44
3	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (3)=(1)-(2)	786,394,258.02	21,008,670.37
225	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ЗАРДЛЫН ДҮН	914,600.00	00.00
225001	Үндсэн хөрөнгө худалдсаны гарз	914,600.00	00.00
4	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ҮР ДҮН (4)=(145-225)	-914,600.00	00.00
5	НИЙТ ҮР ДҮН (5)=(3)+(4)	785,479,658.02	21,008,670.37

2.3 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

/Төгрөгөөр/

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ГҮЙЛГЭЭ		
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (1)	812,915,544.00	1,159,376,200.00
118304	Нохойны албан татвар	00.00	00.00
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	17,344.00	105,000.00
120	Нийтлэг татварын бус орлого	17,344.00	105,000.00
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого	17,344.00	105,000.00
1E+06	Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих	17,344.00	105,000.00
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	812,898,200.00	1,159,271,200.00
1310	Улсын төвлөрсөн төсвөөс	740,209,600.00	1,052,582,900.00
131001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт	740,209,600.00	1,052,582,900.00
1320	Орон нутгийн төсвөөс санхүүжих	72,688,600.00	106,688,300.00
132001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/	72,688,600.00	106,688,300.00
2	НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН (2)	708,527,854.09	1,139,520,305.71
21	УРСГАЛ ЗАРДАЛ	708,527,854.09	1,139,520,305.71
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	690,371,665.81	1,128,278,441.27
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	455,206,248.25	799,070,961.87
210101	Үндсэн цалин	300,143,658.57	448,891,952.92

БНА-2025/181/НА-СТА-ТШЗ



Бууцагаан сумын Цэцэрлэгийн 2024 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайлан

210102	Нэмэгдэл	134,937,194.95	270,856,971.84
210104	Урамшуулал	20,125,394.73	79,322,037.11
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	59,032,155.84	99,084,148.84
210201	Тэтгэврийн даатгал	39,488,578.81	67,140,102.33
210202	Тэтгэмжийн даатгал	4,864,358.94	8,082,790.35
210203	ҮОМШӨ-ний даатгал	3,899,547.17	4,111,826.33
210204	Ажилгүйдлийн даатгал	969,344.35	3,816,017.60
210205	Эрүүл мэндийн даатгал	9,810,326.57	15,933,412.23
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	57,853,911.72	100,884,635.56
210301	Гэрэл, цахилгаан	9,597,171.72	11,087,099.56
210302	Түлш, халаалт	46,456,740.00	88,147,536.00
210303	Цэвэр, бохир ус	1,800,000.00	1,650,000.00
2105	Нормативт зардал	91,115,705.00	100,089,795.00
210502	Хоол, хүнс	91,115,705.00	100,089,795.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	800,000.00	3,000,000.00
210604	Урсгал засвар	800,000.00	3,000,000.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	1,268,100.00	2,872,800.00
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	1,268,100.00	2,872,800.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	25,095,545.00	23,276,100.00
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	21,291,145.00	18,045,000.00
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	3,804,400.00	5,231,100.00
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	18,156,188.28	11,241,864.44
2132	Бусад урсгал шилжүүлэг	4,121,500.00	8,438,200.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	4,121,500.00	8,438,200.00
2134	Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, санхүүжилт	14,034,688.28	2,803,664.44
213403	Төвлөрүүлэх шилжүүлэг	14,034,688.28	2,803,664.44
3	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (3)=(1)-(2)	104,387,689.91	19,855,894.29
	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ГҮЙЛГЭЭ	00.00	00.00
4	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (4)	00.00	00.00
5	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРДЛЫН ДҮН (5)	00.00	8,982,000.00
22	ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	00.00	8,982,000.00
2200	Дотоод эх үүсвэрээр	00.00	8,982,000.00
225106	Биет ба биет бус хөрөнгө худалдан авсан зардал	00.00	8,982,000.00
6	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (6)=(4)-(5)	00.00	-8,982,000.00
8	НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (8)=(3)+(6)+(7)	104,387,689.91	10,873,894.29
9	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	2,179,772.24	106,567,462.15
10	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	106,567,462.15	117,441,356.44

2.4 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

/төгрөгөөр/

Код	Үзүүлэлт	Засгийн газрын оруулсан капитал	Дахин үнэлгээний нөөц	Хуримтлагдсан дүн	Засгийн газрын хувь оролцооний нийт дүн
-----	----------	---------------------------------	-----------------------	-------------------	---

БНА-2025/181/НА-СТА-ТШЗ



Бууцагаан сумын Цэцэрлэгийн 2024 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайлан

C01	2023 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	118,876,104.00	218,496,786.40	890,835,013.25	1,228,207,903.65
C02	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	00.00	00.00	00.00	00.00
C03	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	118,876,104.00	218,496,786.40	890,835,013.25	1,228,207,903.65
C04	Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт	00.00	00.00	00.00	00.00
C05	Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний бууралт	00.00	00.00	00.00	00.00
C06	Орлогын тайланд хүлээн зөвшөөрөөгүй олз, гарз	00.00	00.00	00.00	00.00
C07	Тайлант үеийн үр дүн	00.00	00.00	8,967,005.43	8,967,005.43
C08	2023 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	118,876,104.00	218,496,786.40	1,643,430,453.81	1,980,803,344.21
D01	2023 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	118,876,104.00	218,496,786.40	1,643,430,453.81	1,980,803,344.21
D02	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	00.00	00.00	00.00	00.00
D03	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	118,876,104.00	218,496,786.40	1,643,430,453.81	1,980,803,344.21
D04	Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт, бууралт	00.00	00.00	00.00	00.00
D05	Үндсэн хөрөнгийн өсөлт, бууралт	00.00	00.00	00.00	00.00
D06	Орлогын тайланд хүлээн зөвшөөрөөгүй олз, гарз	00.00	00.00	00.00	00.00
D08	Тайлант үеийн үр дүн	00.00	00.00	21,008,670.37	21,008,670.37
D09	2024 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	118,876,104.00	218,496,786.40	1,664,439,124.18	2,001,812,014.58

2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан /төгрөгөөр/

Эдийн засгийн ангилал	Үзүүлэлт	Тайлант оны		Зөрүү	Хувь
		Батлагдсан төлөвлөгөө	Гүйцэтгэл		
2	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	1,265,919,500	1,145,698,641.27	120,220,859	90.5
21	УРСГАЛ ЗАРДАЛ	1,265,919,500	1,145,698,641.27	120,220,859	91
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	1,257,481,300	1,137,260,441.27	120,220,859	90
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	904,242,400	799,070,961.87	105,171,438	88
210101	Үндсэн цалин	579,995,500	448,891,952.92	131,103,547	77
210102	Нэмэгдэл	296,544,900	270,856,971.84	25,687,928	91
210104	Урамшуулал	27,702,000	79,322,037.11	-51,620,037	286
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	106,646,200	99,084,148.84	7,562,051	93
210201	Тэтгэврийн даатгал	72,520,900	67,140,102.33	5,380,798	93
210202	Тэтгэмжийн даатгал	8,530,200	8,082,790.35	447,410	95
210203	ҮОМШӨ-ний даатгал	4,265,800	4,111,826.33	153,974	96
210204	Ажилгүйдлийн даатгал	4,265,800	3,816,017.60	449,782	89
210205	Эрүүл мэндийн даатгал	17,063,500	15,933,412.23	1,130,088	93
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	103,688,300	100,884,635.56	2,803,664	97
210301	Гэрэл, цахилгаан	13,000,000	11,087,099.56	1,912,900	85
210302	Түлш, халаалт	88,888,300	88,147,536.00	740,764	99
210303	Цэвэр, бохир ус	1,800,000	1,650,000.00	150,000	92

Бууцагаан сумын Цэцэрлэгийн 2024 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайлан

2105	Нормативт зардал	102,384,900	100,089,795.00	2,295,105	98
210502	Хоол, хүнс	102,384,900	100,089,795.00	2,295,105	98
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	3,000,000	3,000,000.00	00	100
210604	Урсгал засвар	3,000,000	3,000,000.00	00	100
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	2,872,800	2,872,800.00	00	100
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	2,872,800	2,872,800.00	00	100
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	34,646,700	32,258,100.00	2,388,600	93
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	26,208,500	23,819,900.00	2,388,600	91
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	8,438,200	8,438,200.00	00	100
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	8,438,200	8,438,200	00	100
2132	Бусад урсгал шилжүүлэг	8,438,200	8,438,200.00	00	100
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	8,438,200	8,438,200.00	00	100
	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	1,265,919,500	1,265,919,500.00	00	100
1310	УЛСЫН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ	1,052,582,900	1,052,582,900.00	00	100
131001	Улсын төсвөөс санхүүжих	1,052,582,900	1,052,582,900.00	00	100
1320	ОРОН НУТГИЙН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ	106,688,300	106,688,300.00	00	100
132001	Орон нутгийн төсвөөс	106,688,300	106,688,300.00	00	100
120004	ТӨСӨВТ БАЙГУУЛЛАГЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНААС	106,648,300	105,000.00	106,543,300.00	0
1200042	Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих	105,000	105,000.00	00.00	100
1200043	Урьд оны үлдэгдлээс санхүүжих	106,543,300	106,543,300.00	00.00	100
4	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	00	106,567,462.15	106,567,462.15	-
5	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	00	117,441,356.44	117,441,356.44	-
6	ТӨСВИЙН БУСАД МЭДЭЭЛЛИЙН АНГИЛАЛ			-	
61	БАЙГУУЛЛАГЫН ТОО	01	1	00	100
610001	Төсвийн байгууллага	01	1	00	100
62	АЖИЛЛАГСАДЫН ТОО	40	35	05	88
620001	Удирдах ажилтан	01	1	00	100
620002	Гүйцэтгэх ажилтан	26	24	02	92
620003	Үйлчлэх ажилтан	13	10	03	77
63	СУРАЛЦАГЧДЫН ТОО (ЖИЛИЙН ДУНДЖААР)	210	210	00	100
631	СУРГУУЛИЙН ӨМНӨХ БОЛОВСРОЛЫН БАЙГУУЛЛАГА	00	1	01	100
631001	Төрийн өмчит СӨБ байгууллага	01	1	01	100

3. САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТОДРУУЛГА

3.1 Байгууллага, түүний үйл ажиллагаа

Бууцагаан сумын Цэцэрлэг нь Бага насны хүүхдийг асран хамгаалах, хүмүүжүүлэх сургах цогц үйл ажиллагаа явуулж хүүхдийн бие бялдар, оюун ухаан, нийгэмших хөгжлийг дэмжих, сургуульд орох бэлтгэлийг хангах чиг үүргийг хэрэгжүүлэн ажилладаг.

Бууцагаан сумын ерөнхий Цэцэрлэг нь Боловсрол, шинжлэх ухааны яамнаас жил бүр дэвшүүлэн тавьсан зорилго зорилтыг хангах үүднээс байгууллагын үйл ажиллагааг хэвийн явуулах чиг үүргийн дагуу Эрхлэгчийн 2024 оны 01 дүгээр сарын 02-ны өдрийн А/01 дүгээр тушаалаар 35 орон тоотой 9 үндсэн бүлэгт 210 хүүхдийг хамруулан цэцэрлэгийн үйл ажиллагаа явуулсан байна.

Нүүдлийн бүлгийн сургалтыг Нарангийн 5 дугаар багт зохион байгуулсан.

3.2 Байгууллагын гадаад, дотоод орчин

Байгууллага нь Төсвийн тухай, Төрийн албаны тухай, Нягтлан бодох бүртгэлийн тухай, Хөдөлмөрийн тухай, Бага, дунд боловсролын тухай, Боловсролын ерөнхий хууль, Сургуулийн өмнөх болон ерөнхий боловсролын тухай хууль, Мэдээллийн ил тод байдлын тухай, Шилэн дансны тухай, Төрийн хэмнэлтийн тухай, Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн тухай, Байгууллагын нууцын тухай, Нийтийн албанд нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай, Гамшгаас хамгаалах тухай, Зөрчил шалган шийдвэрлэх тухай, Зөрчлийн тухай, Нийгмийн даатгалын тухай, Архивын тухай, Хүний хувийн мэдээлэл хамгаалах тухай болон Татварын багц хуулиудыг мөрдөж үйл ажиллагаа явуулж байна.

Тайлант хугацаанд байгууллагын үйл ажиллагаа, санхүү, нягтлан бодох бүртгэлд мөрддөг хууль тогтоомж болон бодлого чиглэлд дараах өөрчлөлт орсон байна. Үүнд:

- Засгийн газрын 2024 оны 01 дүгээр сарын 17-ны өдрийн “Журам батлах тухай” 25 дугаар тогтоолын хавсралт” Боловсролын байгууллагын үйл ажиллагааны болон багшийн ажлын гүйцэтгэл, чанар, үнэлгээний үр дүнд үндэслэн олгох нэмэлт урамшууллыг санхүүжүүлэх журам”
- Засгийн газрын 2024 оны 01 дүгээр сарын 25-ны өдрийн “Хувьсах зардлын хэмжээ, итгэлцүүр журам батлах тухай” 39 дүгээр тогтоол
- Засгийн газрын 2024 оны 2 дугаар сарын 28-ний өдрийн “Тогтоолд хавсралт нэмэх, тогтоолын хавсралт өөрчлөн батлах тухай 84, “Төрийн албаны зарим албан тушаалын цалингийн доод хэмжээг шинэчлэн тогтоох тухай” 128 дугаар тогтоол.

Байгууллагын удирдлагын хэрэгжүүлж буй дотоод хяналтаас төлөвлөлтийн үе шатанд аудитад хамааралтай хяналтыг авч үзэж, гүйцэтгэх үе шатанд хяналтын сорил

гүйцэтгэсний үр дүнд дотоод хяналтын үйл ажиллагааны зохион байгуулалт, хэрэгжилт үр нөлөөтэй байна.

Дотоод аудитын чиг үүрэг, түүний гүйцэтгэсэн ажлын найдвартай байдлын талаар ойлголт олж авсан ба дотоод аудит гүйцэтгээгүй тул аудитад ашиглах баримт материал байхгүй, дотоод аудитораас шууд туслалцаа авах шаардлагагүй гэж үзлээ.

Тайлант онд Боловсролын ерөнхий газраас хяналт, шинжилгээ, дотоод аудитын газраас хяналт шалгалт хийгдсэн байна.

3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал

Санхүүгийн тайланг бүх материаллаг зүйлсийн хувьд холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн эсэх талаар аудитор дүгнэлтээ илэрхийлснээр санхүүгийн тайлангийн зорилтот хэрэглэгчдийн зүгээс үзүүлэх итгэл үнэмшлийн хэмжээг нэмэгдүүлэхэд санхүүгийн тайлангийн аудитын зорилго оршино.

Бууцагаан сумын Цэцэрлэгийн 2024 оны санхүүгийн тайлан дахь ажил гүйлгээг аккруэл сууриар хөтөлж, нийтлэг зорилготой, үнэн зөв толилуулгын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн байна.

Байгууллагын үйл ажиллагаанд мөрдөж буй Баянхонгор аймгийн СТСХ-ээс бэлтгэж гаргасан Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг нь холбогдох хууль тогтоомж, нягтлан бодох бүртгэлийн стандартад нийцсэн, тус байгууллагын үйл ажиллагааны онцлогт тохирсон байна.

3.4 Нягтлан бодох бүртгэлийн гол бодлого, толилуулгад гарсан өөрчлөлтүүд

Бууцагаан сумын Цэцэрлэгийн 2024 оны санхүүгийн тайланг Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, УСНББОУС-1 ын дагуу бэлтгэсэн байна.

Тайлант хугацаанд нягтлан бодох бүртгэлийн бодлогод өөрчлөлт ороогүй байна.

Тайлант оны жилийн эцсийн санхүүгийн байдлын тайлангаарх нийт хөрөнгийн дүн өмнөх оноос 34,063.7 мянган төгрөгөөр буюу 17.2 хувиар өссөн байна.

Хүснэгт 1. Санхүүгийн байдлын тайлангийн үзүүлэлт

/мянган төгрөгөөр/

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өөрчлөлт
А	1	2	3=2-1
Мөнгөн хөрөнгө	106,567.5	117,441.4	10,873.90
Авлага			0.00
Бараа материал	86,470.3	137,323.9	50,853.60
Үндсэн хөрөнгө	2,062,386.80	2,122,711.80	60,325.00
Хуримтлагдсан элэгдэл	-274,621.20	-362,610.00	-87,988.70
Нийт хөрөнгө	1,980,803.40	2,014,867.10	34,063.80
Өр төлбөр		13,055.1	13,055.10
Засгийн газрын хувь оролцоо /Эздийн өмч/	1,980,803.40	2,001,812.00	21,008.70
Өр төлбөр ба цэвэр хөрөнгө/өмчийн дүн	1,980,803.40	2,014,867.10	34,063.70

Эх сурвалж: Бууцагаан сумын Цэцэрлэгийн санхүүгийн тайлан

Дээрх хүснэгтээс харахад Бууцагаан сумын Цэцэрлэгийн 2024 оны үзүүлэлтээс нөлөө бүхий өөрчлөлт гарсан дансанд нь бараа материал, үндсэн хөрөнгийн данс байна.

Тайлант онд оны эхэнд 106,567.5 мянган төгрөгийн мөнгөн хөрөнгийн үлдэгдэлтэй оны эцэст 117,441.4 мянган төгрөгийн өмнөх оноос 10,873.9 мянган төгрөгөөр нэмэгдсэн байна.

Тайланд онд 2024 оны авлага үүсээгүй авлагын үлдэгдэлгүй байна.

Тайлант онд төсвийн хөрөнгөөр 123,256.7 мянган төгрөгийн бараа материал худалдан авч 53,086.1 мянган төгрөгийн бараа материалыг үнэ төлбөргүй орлого авч үйл ажиллагаанд 121,575.4 мянган төгрөгийн бараа материал зарцуулж, Захирлын 2024 оны 12 дугаар сарын 30-ны өдрийн “Эргэлтийн хөрөнгө актлах тухай” А/28 дугаар тушаалаар 3,913.8 мянган төгрөгийн бараа материал акталж, бараа материалын үлдэгдэл 50,853.6 мянган төгрөгөөр нэмэгдсэн байна.

Тайлант онд төсвийн хөрөнгөөр 18,642.0 мянган төгрөгийн үндсэн хөрөнгө худалдаж авсан.

Боловсролын ерөнхий газраас 21,003.0 мянга, 100 жилийн ойн хандиваар хувь хүнээс 20,680.0 мянган төгрөгийн хөрөнгө үнэ төлбөргүй хүлээн авсан орлогоор бүртгэсэн байна.

Нийт 60,325.0 мянган төгрөгөөр үндсэн хөрөнгө нэмэгдсэн байна.

Нийгмийн даатгалын шимтгэлд 1,128.3 мянга, ХХОАТ-т 257.9 мянга, ажиллагсад төлөх өглөг 1,195,8 мянган төгрөг, байгууллагад өглөг 10,473.1 нийт өглөг 13,055.1 мянган төгрөгөөр өглөг нэмэгдсэн байна. “Хос задь” ХХК-д камер тавиулахаар 2024 оны 2 дугаар сарын 29-ний өдөр хийсэн 9,010.0 мянган төгрөгийн гэрээний үлдэгдэл 7,010.0 мянган төгрөг, 8,100.0 мянган төгрөгийн аяга таваг угаагчийн үлдэгдэл төлбөр 2,810.0 мянган төгрөг, Монголын цахилгаан холбоонд 1,173.4 мянган төгрөгийн төлбөр төлөгдөхөөс үлдэгдэл 653.1 мянган төгрөгийн төлөгдөөгүй үлдэгдэл байна.

Засгийн газрын оролцоо дансны үлдэгдэл тайлант үеийн үр дүнгийн 21,008.7 мянган төгрөгөөр нэмэгдэж, 2,001,812.0 мянган төгрөг болсон байна.

Өмчийн өөрчлөлтийн тайлангаар өмнөх оны үр дүн, хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү данс өөрчлөлтгүй, тайлант үеийн үр дүн 21,008.7 мянган төгрөгөөр нэмэгдэж 2,001,812.0 мянган төгрөг болсон байна.

3.5 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн захирагч нь тус хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

3.5.1 Төсвийн төлөвлөлт

Тус байгууллагын 2024 оны төсвийн төсөлд зардлыг санхүүжүүлэх эх үүсвэрийг улсын төсвөөс 821,274.7 мянган төгрөгөөр төлөвлөж, зарлагыг 821,274.7 мянган төгрөгөөр тооцон дээд шатны төсвийн захирагчид хүргүүлсэн байна.

Төсвийн саналаас 16,113.3 мянган төгрөгөөр нэмэгдэж 837,388.0 мянган төгрөгөөр анх батлагдсан ба тодотголоор 1,265,919.5 мянган төгрөг болгож 428,531.5

мянган төгрөгөөр нэмэгдүүлэн баталсан байна. Энэ нь багш ажилчдын цалин хөлс нэмэгдсэнтэй холбоотой байна.

3.5.2 Төсвийн гүйцэтгэл

Тайлант онд тус байгууллага төсвийн захирагчийн хэрэгжүүлэх 71801 (Ерөнхий боловсрол) хөтөлбөрийн арга хэмжээг санхүүжүүлэхээр улсын төсвөөс баталсан 1,052,738.7 мянган төгрөгийн санхүүжилтийг авч өмнөх оны харилцах дансны үлдэгдлээс 106,543.3 мянга, үйл ажиллагааны орлогоос 105.0 мянга, орон нутгийн төсвөөс 106,688.3 мянган төгрөг нийт 1,265,919.5 мянган төгрөгийн эх үүсвэртэй гүйцэтгэлээр 1,145,698.6 мянган төгрөгийг зарцуулж, 117,441.3 мянган төгрөг харилцах дансанд үлдэгдлээр зарцуулагдаагүй байна.

Орон нутгийн төсвөөс олгохоор баталсан 106,688.3 мянган төгрөгийн санхүүжилтийг авч, гүйцэтгэлээр батлагдсан санхүүжилтийн 97.4 хувь буюу 103,884.6 мянган төгрөгийг зарцуулж, 2,803.7 мянган төгрөгийг орон нутгийн төсөвт төвлөрүүлжээ.

Хүснэгт 2. Хөтөлбөр, арга хэмжээний төлөвлөгөө, гүйцэтгэл

/мянган төгрөгөөр/

№	Хөтөлбөр, арга хэмжээ	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү	Биелэлт
2	80233-Хүүхэд хамгаалал	1,271.60	1,270.90	0.7	99.9%
3	81605 Эрүүл мэндийг дэмжих	1,947.30	1,947.30	0.0	100.0%
4	81807-Хүүхдийн хоол	101,691.90	99,396.8	2,295.1	97.7%
5	81844 гүнгийрүүлсэн сургалт	105.00	105.00	0.0	100.0%
6	81816 Хүүхдэд ээлтэй сургалтын орчин	3,151.00	3,151.00	0.0	100.0%
7	81823 Боловсролын байгууллагын багш	1,947.30	1,947.30	0.0	100.0%
8	81832-Нүүдлийн бүлэгт хамруулах	6,261.80	6,261.80	0.0	100.0%
9	81834 Боловсролын стандарт, сургалтын	1,007,759.60	896,272.10	111,487.5	88.9%
10	81835 Сургалтын хэвийн үйл ажиллагаа	35,095.70	31,461.80	3,633.9	89.6%
12	80112 Нийтлэг үйлчилгээ	106,688.30	103,884.60	2,803.7	97.4%
	ДҮН	1,265,919.50	1,145,698.60	120,220.9	90.5%

Эх сурвалж:2024 оны төсвийн гүйцэтгэлийн тайлан

Батлагдсан төсөв, гүйцэтгэл, түүний хэтрэлт, хэмнэлтийг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.5-д харуулав.

4. АУДИТЫН ТАЙЛАН

4.1 Ерөнхий зүйл

Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1-д “Төрийн аудитын байгууллага аудитын дүнд үндэслэн дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргана” гэж заасны дагуу Бууцагаан сумын Цэцэрлэгийн 2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайланг танилцуулж байна.

Аудитын тайланд аудит хийгдэх байгууллага, түүний орчин, аудитад хамааралтай дотоод хяналт, нягтлан бодох бүртгэл, санхүүгийн тайлагналын үзэл баримтлал, аудитаар илрүүлсэн буруу илэрхийлэл, түүнийг шийдвэрлэсэн байдал, дараагийн аудитаар анхаарах асуудал болон аудиторын дүгнэлт, дүгнэлтийн үндэслэлийг хураангуйлан толилуулав.

Аудитыг Номгон Аудит ХХК-ийн захирал, аудитор Г.Саранчимэг багийг ахалж аудитор О.Мандах гүйцэтгэж, хяналтыг Баянхонгор аймаг дахь төрийн аудитын менежер М.Алтантуяа, газрын дарга, тэргүүлэх аудитор Б.Мөнхбат нар тус тус хэрэгжүүлсэн.

Бууцагаан сумын Цэцэрлэгийн 2024 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл, аудитад шаардлагатай баримт материалыг Номгон Аудит ХХК-д 2025 оны 1 дүгээр сарын 25-ны өдөр ирүүлсэн байна.

Тайлант онд хөрөнгө захиран зарцуулах 1 дүгээр гарын үсгийг Цэцэрлэгийн эрхлэгч Д Гэрлээ, 2 дугаар гарын үсгийг нягтлан бодогч Д.Мөнхтуяа нар зурж, нярваар 2024.08.30-ны өдөр хүртэлх хугацаанд Д. Цамба, 2024.09.01-ний өдрөөс А.Минжсор нар ажилласан байна.

4.2 Материаллаг байдал

Төлөвлөлтийн болон гүйцэтгэлийн материаллаг байдлыг АДБОУС 2320 дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр 2024 оны батлагдсан төсвийн зардлыг сонгож материаллаг байдлын түвшинг 1.0 хувиар тооцож, материаллаг буруу илэрхийллийн эрсдэлийг Дунд гэж үнэллээ.

Төлөвлөлтийн материаллаг байдлыг оны батлагдсан төсөв 5,743,571.9 мянган төгрөгөөс 1.0 хувиар буюу 11,829.3 мянган төгрөгөөр, гүйцэтгэлийн материаллаг байдлыг төлөвлөлтийн материаллаг байдлын 75 хувиар буюу 8,871.9 мянган төгрөгөөр тогтоосон.

4.3 Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилт

Тухайн байгууллага нь Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хязгаарлалттай холбоотой заалтуудыг зөрчөөгүй болно.

4.4 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

АДБОУС 4000.16-д нийцлийн аудитыг санхүүгийн тайлангийн аудиттай хослуулан хийх тохиолдолд аудитор аль стандартыг дагаж мөрдөхийг үнэлэх, нийцлийн асуудлын талаарх дүгнэлтийг санхүүгийн тайланд өгөх аудиторын дүгнэлтээс тусад нь салгах хэрэгтэй гэж заасан байна.

4.4.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт

Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйл, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор баталсан “Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам”-ын заалтыг хэрэгжүүлэх зорилгоор www.shilendans.gov.mn цахим хуудсанд холбогдох мэдээллийг оруулсан байх үүрэгтэй.

Байгууллагын шилэн дансны нэгдсэн цахим хуудаст цалингийн зардлаас бусад таван сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий орлогын 1,316,849.5 мянган төгрөгийн 27 гүйлгээ, зарлагын 178,981.9 мянган төгрөгийн 21 гүйлгээ, хуулийн хугацаанд мэдээлсэн байна. 1 мэдээг хугацаа хоцроон мэдээлсэн байна.

Нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийн түвшинд хэрэгжүүлсэн горим сорилд үндэслэн шилэн дансанд байршуулсан мэдээлэл нь шилэн дансны тухай хууль тогтоомжийн холбогдох заалттай *нийцсэн* гэж дүгнэлээ.

4.4.2 Худалдан авах ажиллагааны талаар

Тус сургууль нь Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр, бараа, ажил үйлчилгээ худалдан авах үнэлгээний хороог захирлын 2024 оны 02 дугаар сарын 13 ны өдрийн А/02 дугаар тушаалаар 5 хүний бүрэлдэхүүнтэй томилж, цэцэрлэгийн хүүхдийн хоолны 71,975.9 мянган төгрөгийн материал нийлүүлэх гүйцэтгэгчийг сонгон шалгаруулах тендерийг харьцуулалтын аргаар зохион байгуулахаар 2024 оны 2 дугаар сарын 15-ны өдрөөс 02 дугаар сарын 29-ний өдрийг хүртэл ажлын 10 хоногт багтаан худалдан авах ажиллагааны цахим систем www.tender.gov.mn-д тендерийн бичиг баримтыг байршуулсан байна. Тендерийг оролцогч ирээгүй тул 2024 оны 04 дүгээр сарын 19-нээс 05 дугаар сарын 01-нийг хүртэлх хугацаанд дахин зарласан байна

Цэцэрлэгийн хүүхдийн хоолны материал нийлүүлэх тендерийг 1 багц, болгон зарласан байна.

Цэцэрлэгийн хүүхдийн хоолны материал нийлүүлэх тендерт “Үүрээр цацрах гэгээ” ХХК шалгарч 71,945,0 мянган төгрөгийн хүүхдийн хоолны материал нийлүүлэхээр 2024 оны 05 дугаар сарын 22-ны өдрөөс 2024 оны 12 дугаар сарын 31-ний өдөр хүртэлх хугацаанд байгуулан ажилласан байна.

Худалдан авах гэрээг дүгнэхэд зарим хүнсний барааны гэрээний үнэ зөрчигдсөн байсныг 2 тал харилцан дүгнэсэн байна. Цаашид Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр, бараа, ажил үйлчилгээ худалдан авах хуулийн хэрэгжилтийг ханган ажиллах албан шаардлага өглөө.

4.5 Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт

4.5.1 Завсрын аудитын талаар

Завсрын аудит хийгдээгүй болно.

4.5.2 Өмнөх аудитын мөрөөр авч хэрэгжүүлсэн арга хэмжээний үр дүн

Өмнөх оны санхүүгийн тайлангийн аудитыг Аймгийн аудитын газрын аудитор Б.Нарангэрэл гүйцэтгэж, 304.8 мянган төгрөгийн 1 төлбөрийн акт, 44,080.0 мянган төгрөгийн 3 албан шаардлага, 926.7 мянган төгрөгийн 2 зөвлөмж тогтоон байгууллагын удирдлагад хүргүүлсэн байна.

Хүснэгт 4. Төлбөрийн акт, албан шаардлага, зөвлөмжийн хэрэгжилт

/мянган төгрөгөөр/

Үзүүлэлт	Өмнөх аудитын үзүүлэлт		Биелэлт		
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Хувь
Акт	1	304,8	1	304,8	100

Бууцагаан сумын Цэцэрлэгийн 2024 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайлан

Албан шаардлага	3	44,080.0	3	44,080.0	100
Зөвлөмж	2	926.7	2	926.7	100
Нийт дүн	6	45,311.5	6	45,311.5	100

Эх сурвалж: төлбөрийг 2024 оны 06.03 –ны төлбөрийн баримт

Аудитаар өгсөн төлбөрийн актын хэрэгжилтийг тус байгууллагаас 2024.06.04-ны өдөр 31 дүгээр албан бичгээр ирүүлж бүрэн биелүүлж ажиллажээ.

4.6 Дараагийн аудитаар анхаарах асуудал

Балансын урамшууллыг олгохдоо “Өөрчлөлтгүй дүгнэгдсэн боловч акт, албан шаардлага, зөвлөмж авсан байхад нягтлан бодогчид үндсэн цалингийн 2 сартай тэнцэх хэмжээний урамшуулал олгох тушаал гарган олгосон байна. Дараагийн аудитаар үр дүнтэй нь уялдуулан олгосныг авч үзэх шаардлагатай.

5. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ

Аудитаар 1,275.1 мянган төгрөгийн 2 алдаа илэрснийг аудитын явцад залруулав. Үүнд:

-Нийгмийн даатгалын шимтгэлийн 79,3 мянга, даатгуулагчийн цалингаас суутгасан нийгмийн даатгалын шимтгэлийн хувь хэмжээ, нийгмийн даатгалд мэдээлсэн мэдээний хувь хэмжээ зөрүүтэйгээс 1,195.8 мянган төгрөгийг 3 ажилтанд буцаан олгохоор өглөгөөр санхүүгийн тайланд тусгаагүйг залруулан бүртгэсэн.

Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.2.5.”дансны өглөг, авлага ба төлбөрийн тооцоог хянах, ажил, гүйлгээг гарахаас нь өмнө хянан, баталгаажуулах” гэсэн заалтыг хэрэгжүүлээгүй, “Нийцсэн бөгөөд зохистой байх” гэсэн батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Аудитаар нийт 11,229.7 мянган төгрөгийн 6 зөрчил³ илэрсэнд 3,425.8 мянган төгрөгийн 2 төлбөрийн акт, 7,803.9 мянган төгрөгийн 4 албан шаардлага тогтоов.

5.1 Төлбөрийн акт

1. Цэцэрлэгийн эрхлэгчийн 2024 оны 11 дүгээр сарын 24 өдрийн “Байгууллагын гүйцэтгэлийн үнэлгээний нэмэлт урамшуулал олгох хуваарь батлах тухай” А/ 20 дугаар тушаалаар олгосон 8,438,2 мянган төгрөгийн нэмэлт урамшууллаас 843.8 мянган төгрөгийн ХХОАТ суутган тооцоо хийгээгүй байна.

Энэ нь ХХОАТ-ын тухай хуулийн 7 дугаар зүйлийн 7.1-д “Албан татвар төлөгчийн цалин, хөдөлмөрийн хөлс, шагнал, урамшуулал болон тэдгээртэй адилтгах хөдөлмөр эрхлэлтийн орлогод дараах орлогыг хамруулна”, 7.1.1-д “ажил олгогчтой байгуулсан хөдөлмөрийн гэрээнд заасны дагуу авч байгаа үндсэн цалин, нэмэгдэл хөлс, нэмэгдэл, шагнал, урамшуулал, амралтын олговор, тэтгэвэр, тэтгэмж, тэдгээртэй

³ Хүчин төгөлдөр үйлчилж буй хууль тогтоомжид харшлах байгууллага, түүний удирдлага, байгууллагад ажилладаг бусад хувь хүний санаатай болон санамсаргүй үйлдэл, эс үйлдэл.

адилтгах бусад орлого;" гэсэн заалттай нийцэхгүй, үнэн зөв байх, нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийг хангаагүй байна.

Шийдвэрлэсэн нь:

Гүйцэтгэлийн үнэлгээний урамшууллаас хуулийн дагуу суутган тооцоогүй 843.2 мянган төгрөгийг төсвийн шууд захирагч, нягтлан бодогч нараар төлүүлэх төлбөрийн акт тогтоов.

2. Цалингийн зардлаас 2,582.0 төгрөгийн бичиг хэргийн материал авч бүлэг хооронд гүйлгэн зориулалт бусаар зарцуулсан байна.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.1 "төсвийг үр ашигтай хэмнэлттэй байхаар төлөвлөж зарцуулах", 16.5.5 "батлагдсан төсвийг зориулалтын дагуу зарцуулах", Засгийн газрын 2024 оны 01 дүгээр сарын 25-ны өдрийн "Хувьсах зардлын хэмжээ, итгэлцүүр, журам батлах тухай" 39 дүгээр тогтоолын 4 дүгээр хавсралт "Хувьсах зардал болон гүйцэтгэл үр дүнд суурилан санхүүжүүлэх журмын хавсралт "Сургуулийн өмнөх болон ерөнхий боловсролын нэг суралцагчид ногдох хувьсах зардлын хэмжээний бүрэлдэхүүн, зардлын зориулалт, эдийн засгийн ангиллын дэлгэрэнгүй заавар, Монгол улсын Сангийн сайдын 2023 оны 11 дүгээр сарын 20-ны өдрийн Ангилал шинэчлэн батлах тухай 211 дүгээр тушаалын 2 дугаар хавсралтын заалтуудыг тус тус зөрчсөн байна.

Шийдвэрлэсэн нь:

Цалингийн зардлаас төсвийг зориулалт бусаар зарцуулсан 2,582.0 мянган төгрөгийг хичээл практикийн зардлаас төлж барагдуулах төлбөрийн акт тогтоов.

5.2 Албан шаардлага

1. Цэцэрлэгийн хүүхдийн хоолны материал нийлүүлэх тендерт шалгарч материал нийлүүлэх гэрээ хийсэн "Үүрээр цацрах гэгээ" ХХК "–наас нийлүүлсэн бараа материалыг гэрээний үнээр тооцоход 3573.0 мянган төгрөгийн үнийн зөрүүтэй нийлүүлэгдсэн байна.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.1 "төсвийг үр ашигтай хэмнэлттэй байхаар төлөвлөж зарцуулах" заалт, Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил үйлчилгээ, худалдан авах тухай хуулийн 39 дүгээр зүйлийн 39.3.1 дах "гэрээний үнэ" заалтыг зөрчсөн байна.

Шийдвэрлэсэн нь:

Цаашид Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил үйлчилгээ, худалдаан авах тухай хуулийн хэрэгжилтийн ханган гэрээний үнийг мөрдөж төсвийг үр ашигтай зарцуулах албан шаардлага өгөв.

2. Ажилчдын үзлэг шинжилгээний төлбөрт Монголын судлаач эмч нарын нийгэмлэг төрийн бус байгууллагатай гэрээ байгуулан 1,380.0 мянган төгрөг шилжүүлсэн.

Энэ нь БШУ-ны сайд, Эрүүл мэндийн сайдын хамтарсан тушаал 2022 оны 06.29 - ны өдрийн Багшийн эрүүл мэндийн талаар авах зарим арга хэмжээний тухай А/232, А/340 дугаар тушаалын 2.2 дах заалт /багш нарын урьдчилан сэргийлэх нэмэлт үзлэг, оношилгоог магадлан итгэмжлэгдсэн төрийн болон хувийн хэвшлийн эрүүл мэндийн байгууллагатай гэрээ байгуулан гүйцэтгүүлж, төлбөрийг зохих журмын дагуу санхүүжүүлж тайлагнах, БШУ-ны сайдын 2022 оны 07 дугаар сарын "Заавар батлах

тухай А/259 дүгээр тушаал хавсралт 1.4 "Сонгосон эрүүл мэндийн байгууллага" цаашид "Эрүүл мэндийн байгууллага гэх/ гэдэгт магадлан итгэмжлэгдсэн, дуран, авиа, нян судлалын лаборатори бүхий ЭМДЕГ-тай үзлэг оношилгоо хийх гэрээ байгуулсан, тухайн цэцэрлэг, ерөнхий боловсролын сургуулийн багшийн эрүүл мэндийн нэмэлт үзлэг, оношилгоо хийлгэхээр сонгосон төрийн болон хувийн хэвшлийн эрүүл мэндийн байгууллагыг ойлгоно. гэсэн заалтуудыг зөрчсөн байна.

Шийдвэрлэсэн нь: Цаашид үзлэг шинжилгээг магадлан итгэмжлэгдсэн эрүүл мэндийн байгууллагыг сонгон эрүүл мэндийн үзлэгт хамрагдах албан шаардлага хүргүүлэв.

3. Боловсрол Шинжлэх ухааны яамны 2024 оны 06 дугаар сарын 24-ны өдрийн 2/2772 дугаар албан бичгийг үндэслэн аймгийн Боловсролын газрын даргын 2024 оны 07 дугаар сарын 09-ний өдрийн "Урамшуулал олгох тухай" Б/42 дугаар тушаалаар төсвийн шууд захирагчид балансын урамшуулал нэг сарын цалинтай тэнцэх 1,544.0 мянган төгрөгийн урамшуулал олгосон байна.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 6.4.1 "төсвийг үр ашигтай хэмнэлттэй байхаар төлөвлөж зарцуулах", Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 23 дугаар зүйлийн 23.2-т "Нягтлан бодох бүртгэлийн ажилд үр бүтээл гарган ажилласан нягтлан бодох бүртгэлийн ажилтныг шагнаж урамшуулж болно" гэсэн заалтыг тус тус зөрчсөн байна

Шийдвэрлэсэн нь: Төсвийн шууд захирагч нарт балансын урамшуулал олгодог байдлыг таслан зогсоох зөрчил арилгах албан шаардлага хүргүүлэв.

4. Боловсролын байгууллагын онцлогоос шалтгаалж 2024 оны 6 дугаар сард олгосон ээлжийн амралтын мөнгийг нийгмийн даатгалын мэдээнд 6-8 саруудад мэдээлэхдээ 4 ажилтны цалингаас суутган тооцсон нийгмийн даатгалын шимтгэл 1,049.0 мянга, ХХАОТ 257.9 мянга нийт 1,306.9 мянган төгрөгийг нягтлан бодох бүртгэлд бүртгээгүй, нийгмийн даатгалын шимтгэлийн мэдээ, татварын мэдээнд тайлагнаагүй байна.

Дээрх зөрчил нь Нийгмийн даатгалын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.1. "Ажил олгогч даатгуулагчийн цалин хөлс, түүнтэй адилтгах орлогоос нийгмийн даатгалын шимтгэлийг сар бүр тооцон суутгаж, ажил олгогчийн цалин хөлсний сан, түүнтэй адилтгах орлогоос тооцсон шимтгэлийн хамт тухайн сард багтаан нийгмийн даатгалын санд төлнө" гэсэн заалтыг зөрчиж, Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.2.5. "дансны өглөг, авлага ба төлбөрийн тооцоог хянах, ажил, гүйлгээг гарахаас нь өмнө хянан, баталгаажуулах" гэсэн заалтыг хэрэгжүүлээгүй байна., "Нийцсэн бөгөөд зохистой байх" гэсэн батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Шийдвэрлэсэн нь:

ХХАОТ-ын тайлан, Нийгмийн даатгалын шимтгэлийн мэдээнд 4 ажилтны цалинг нөхөн мэдээлж зөрчлийг арилгах албан шаардлага өгөв.

Дээрх албан шаардлага, төлбөрийн актын биелэлтийг төрийн аудитын байгууллагад 2025 оны 5 дугаар сарын 25-ны өдрийн дотор ирүүлнэ үү.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

6. Аудитаар илэрсэн алдаа, зөрчлийн нэгтгэл

Санхүүгийн тайлангийн алдааны нэгтгэл

БНА-2025/181/НА-СТА-ТШЗ



Бууцагаан сумын Цэцэрлэгийн 2024 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайлан

Адлааны товч утга	Нийт алдаа		Мэдээллийг тусгаагүй орхигдуулсан		Буруу тусган илэрхийлсэн		Үүнээс			
							Залруулсан		залруулаагүй	
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
Санхүүгийн тайлантай холбоотой алдаа										
Нийгмийн даатгалын шимтгэл төлөлтийн өглөгийг 79.3 мянган төгрөгөөр дутуу тусгасан нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.2.5."дансны өглөг, авлага ба төлбөрийн тооцоог хянах, ажил, гүйлгээг гарахаас нь өмнө хянан, баталгаажуулах" гэсэн заалтад нийцэхгүй байна.	1	79.3	1	79.3			1	79.3	0	0
Ажиллагсад өгөх өглөгийг 1195.8 мянган төгрөгөөр дутуу тусгасан нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.2.5."дансны өглөг, авлага ба төлбөрийн тооцоог хянах, ажил, гүйлгээг гарахаас нь өмнө хянан, баталгаажуулах" гэсэн заалтад нийцэхгүй байна.	1	1195.8	1	1195.8			1	1195.8		
Нийт дүн	2	1,275.1	2	1,275.1			2	1,275.1		

Санхүүгийн тайлангийн аудитын зөрчлийн нэгтгэл

Зөрчлийн товч утга	Нийт зөрчил		/мянган төгрөгөөр/					
			Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж	
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
Санхүүгийн тайлантай холбоотой зөрчил								
Цалингийн зардлаас бусад үйлчилгээний зардалд 2582.0 мянган төгрөг төлсөн нь Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.1 мөн 16,5.5, Засгийн газрын 2024 оны 01 дүгээр сарын 25-ны өдрийн "Хувьсах зардлын хэмжээ, итгэлцүүр, журам батлах тухай" 39 дүгээр тогтоолын 4 дүгээр хавсралт заасан заалтад нийцэхгүй байна.	1	2,582.0	1	2,582.0				
Урамшууллаас ХХОАТ 843,8 мянган төгрөгийн суутгал хийгээгүй нь ХХОАТ-ын тухай хуулийн 7 дугаар зүйлийн 7.1.Албан татвар төлөгчийн цалин, хөдөлмөрийн хөлс, шагнал, урамшуулал болон тэдгээртэй адилтгах хөдөлмөр эрхлэлтийн орлогод дараах орлогыг хамруулна мөн 7.1.1 заалтад нийцэхгүй байна.	1	843.8	1	843.8				
4 ажилтны цалинг нийгмийн даатгалын шимтгэл төлөлт, татварын мэдээнд мэдээлээгүйгээс Нийгмийн даатгалын шимтгэлд 1049.0 мянган төгрөг, ХХОАТ-атварт 257.9 мянган төгрөгийн өглөг үүссэн нь Нийгмийн даатгалын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.1 дах заалтад нийцэхгүй байна.	1	1,306.9			1	1,306.9		
"Үүрээр цацрах гэгээ" ХХК "–наас нийлүүлсэн бараа материалыг гэрээний үнээр тооцоход 3573.0 мянган	1	3573.0			1	3,573.0		



Бууцагаан сумын Цэцэрлэгийн 2024 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайлан

төгрөгийн үнийн зөрүүтэй нийлүүлэгдсэн байгаа нь Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.1 мөн, Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил үйлчилгээ, худалдан авах тухай хуулийн 39 дүгээр зүйлийн 39.3.1 дах заалтад нийцэхгүй байна.							
Ажилчдын үзлэг шинжилгээний төлбөрт Монголын судлаач эмч нарын нийгэмлэг төрийн бус байгууллагатай гэрээ байгуулан 1380.0 мянган төгрөг шилжүүлсэн нь БШУ-ны сайд, Эрүүл мэндийн сайдын хамтарсан тушаал 2022 оны 06.29 -ны өдрийн Багшийн эрүүл мэндийн талаар авах зарим арга хэмжээний тухай А/232, А/340 дугаар тушаалын 2.2 дах заалт, БШУ-ны сайдын 2022 оны 07 дугаар сарын "Заавар батлах тухай А/259 дүгээр тушаал хавсралт 1.4 заалтад нийцэхгүй байна.	1	1380.0			1	1380.0	
Төсвийн шууд захирагчид балансын урамшуулал нэг сарын цалинтай тэнцэх 1,544.0 мянган төгрөгийн урамшуулал олгосон нь Төсвийн тухай хуулийн 6.4.1 - төсвийг үр ашигтай хэмнэлттэй байхаар төлөвлөж зарцуулах мөн 16,5,5 - батлагдсан төсвийг зориулалтын дагуу зарцуулах гэсэн заалт, Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 23 дугаар зүйлийн 23.2-т нийцэхгүй байна.	1	1544.0			1	1544.0	
Нийт дүн	6	11,229.7	2	3,425.8	4	7,803.9	

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

--oOo--



БАЯНХОНГОР АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР
АЛБАН ШААРДЛАГА

2025 оны 02 сарын 25 өдөр

Дугаар 118/14225456/5711-2025/81/
КА-СТА-ТШЗ

Номгон

Зөрчил арилгуулах тухай

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлд тодорхойлсон Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд Бууцагаан сумын Цэцэрлэгийн 2024 оны жилийн эцсийн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитаар дараах зөрчил илэрлээ. Үүнд:

Ажилчдын үзлэг шинжилгээний төлбөрт Монголын судлаач эмч нарын нийгэмлэг төрийн бус байгууллагатай гэрээ байгуулан 1,380,000 /Нэг сая гурван зуун наян мянган/ төгрөг шилжүүлсэн.

Энэ нь БШУЯ-ны сайд, Эрүүл мэндийн сайдын хамтарсан тушаал 2022 оны 06.29 -ны өдрийн Багшийн эрүүл мэндийн талаар авах зарим арга хэмжээний тухай А/232, А/340 дугаар тушаалын 2.2 дах заалт /багш нарын урьдчилан сэргийлэх нэмэлт үзлэг, оношилгоог магадлан итгэмжлэгдсэн төрийн болон хувийн хэвшлийн эрүүл мэндийн байгууллагатай гэрээ байгуулан гүйцэтгүүлж, төлбөрийг зохих журмын дагуу санхүүжүүлж тайлагнах, БШУЯ-ны сайдын 2022 оны 07 дугаар сарын "Заавар батлах тухай А/259 дүгээр тушаал хавсралт 1.4 "Сонгосон эрүүл мэндийн байгууллага" цаашид "Эрүүл мэндийн байгууллага гэх/ гэдэгт мадаглан итгэмжлэгдсэн, дуран, авиа, нян судлалын лаборатори бүхий ЭМДЕГ-тай үзлэг оношилгоо хийх гэрээ байгуулсан, тухайн цэцэрлэг, ерөнхий боловсролын сургуулийн багшийн эрүүл мэндийн нэмэлт үзлэг, оношилгоо хийлгэхээр сонгосон төрийн болон хувийн хэвшлийн эрүүл мэндийн байгууллагыг ойлгоно гэсэн заалтуудыг зөрчсөн байна. "Нийцсэн бөгөөд зохистой байх" гэсэн батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.1 дэх "Шалгагдагч этгээд хууль тогтоомж, захиргааны хэм хэмжээний болон бусад эрх зүйн акт зөрчсөн, хуулиар хүлээсэн албан үүргээ биелүүлээгүй бол алдаа, зөрчлийг таслан зогсоох, давтан гаргуулахгүй байх талаар байгууллага, албан тушаалтанд албан шаардлага өгнө", Монгол Улсын Ерөнхий аудиторовын 2020 оны А/95 дугаар

5040226

тушаалаар баталсан “Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох журам”-ын 4 дүгээр зүйлийн 4.2.1.11 дахь “хууль тогтоомж, гэрээ, хэлцэл зөрчсөн алдаа, зөрчлийг таслан зогсоож, давтан гаргуулахгүй байх үр нөлөөтэй гэж үзсэн бусад нөхцөл байдал” гэснийг тус тус үндэслэн **ШААРДАХ нь:**

1. Үзлэг шинжилгээг магадлан итгэмжлэгдсэн эрүүл мэндийн байгууллагыг сонгон эрүүл мэндийн үзлэгт хамрагдан, зөрчлийг арилган биелэлтийг 2025 оны 05 дугаар сарын 30-ны дотор Баянхонгор аймаг дахь Төрийн аудитын газарт ирүүлэх¹.

2. Цаашид алдаа, зөрчлийг давтан гаргахгүй байх, хууль тогтоомжийг хэрэгжүүлж ажиллахыг Бууцагаан сумын Цэцэрлэгийн эрхлэгч Д. Гэрлээ, нягтлан бодогч Д. Мөнхтуяа нарт даалгав².

АЛБАН ШААРДЛАГЫГ ӨГСӨН:

БАЯНХОНГОР АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗРЫН
ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР:  Б.МӨНХБАТ

НОМГОН АУДИТ ХХК-ИЙН
АУДИТОР:  О.МАНДАХ

6417143544
БҮОА0067 9007423

¹ Монгол Улс, Баянхонгор аймаг, Баянхонгор сум, Нутгийн удирдлагын ордон 3 давхар

² Захиргааны ерөнхий хуулийн 94 дүгээр зүйлийн 94.1 “Захиргааны актыг энэ хуульд заасан журмын дагуу мэдэгдсэнээс хойш 30 хоногийн дотор гомдлыг хянан шийдвэрлэх захиргааны байгууллагад гаргана.”

³ Төрийн аудитын тухай хуулийн 42.1-т энэ хуулийн 16 дугаар зүйлд заасан этгээд, хүчин төгөлдөр болсон албан шаардлага, төлбөрийн актыг хугацаанд нь биелүүлээгүй, аудитын үйл ажиллагаанд саад учруулсан, санхүүгийн тайлангийн аудитаар сөрөг дүгнэлт авсан, хуулиар хориглосон үйл ажиллагаа явуулсан, албан үүргээ биелүүлээгүй, албан тушаалын бүрэн эрхээ хэтрүүлсэн нь аудитаар илэрсэн бол тухайн албан хаагчид сахилгын шийтгэл ногдуулах үндэслэл болно



БАЯНХОНГОР АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР
АКТ

2025 оны 2 сарын 25 өдөр

Дугаар 48/14225456/БНА-2025/181/
НА-СТА-ТШЗ

Номгон

Төлбөр барагдуулах тухай

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлд тодорхойлсон Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд Бууцагаан сумын Цэцэрлэгийн 2024 оны жилийн эцсийн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитаар дараах зөрчил илэрлээ. Үүнд:

Цалингийн зардлаас 2,582,000 /Хоёр сая таван зуун наян хоёр мянган/ төгрөгийн бичиг хэргийн материал авч зориулалт бусаар зарцуулсан.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.5.5 дахь "батлагдсан төсвийг зориулалтын дагуу зарцуулах", мөн 6 дугаар зүйлийн 6.4.1 " төсвийг үр ашигтай хэмнэлттэй байхаар төлөвлөж зарцуулах" заалт, Засгийн газрын 2024 оны 01 дүгээр сарын 25-ны өдрийн "Хувьсах зардлын хэмжээ, итгэлцүүр, журам батлах тухай" 39 дүгээр тогтоолын 4 дүгээр хавсралт "Хувьсах зардал болон гүйцэтгэл үр дүнд суурилан санхүүжүүлэх журмын хавсралт "Сургуулийн өмнөх болон ерөнхий боловсролын нэг суралцагчид ногдох хувьсах зардлын хэмжээний бүрэлдхүүн, зардлын зориулалт, эдийн засгийн ангилалын дэлгэрэнгүй заавар, Сангийн сайдын 2023 оны 11 дүгээр сарын 20-ны өдрийн Ангилал шинэчлэн батлах тухай 211 дүгээр тушаалын 2 дугаар хавсралт, дах заалтуудыг зөрчиж Ангилал, Үнэн ба зөв байх батламж мэдэгдэлтэй нийцэхгүй байна.


Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.2 дахь "Шалгагдагч этгээд төсөв, санхүү, нягтлан бодох бүртгэлийн үйл ажиллагаа болон төсвийн орлого бүрдүүлэх, зарцуулах, нийтийн өмч, хөрөнгө олж бэлтгэх, ашиглах, зарцуулах, хадгалах, хамгаалахтай холбоотой хууль тогтоомж, захиргааны хэм хэмжээний болон бусад эрх зүйн акт зөрчсөн бол төлбөрийн акт тогтооно", Монгол Улсын Ерөнхий аудиторовын 2020 оны А/95 дугаар тушаалаар баталсан "Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох журам"-ын 4 дүгээр зүйлийн 4.2.3.8 дахь "Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.2-т заасан бусад нөхцөл байдал үүссэн" гэснийг тус тус үндэслэн **ТОГТООХ нь:**


5050092

1.Цалингийн зардлаас зориулалт бусаар зарцуулсан 2582000/ Хоёр сая таван зуун наян хоёр мянган/ төгрөгийг хичээл практикийн зардлаас төлүүлж төлбөрийг Баянхонгор аймгийн Төрийн сан дахь бусад татвар хураамжийн орлогын 100030000947 тоот дансанд төвлөрүүлэх.

2.Төлбөрийн актыг бүрэн барагдуулж, санхүүгийн баримтыг 2025 оны 05 дугаар сарын 30-ны дотор Баянхонгор аймаг дахь Төрийн аудитын газарт ирүүлэхийг Бууцагаан сумын Цэцэрлэгийн эрхлэгч Д.Гэрлээ нягтлан бодогч Д.Мөнхтуяа нарт хариуцуулав¹.

ТӨЛБӨРИЙН АКТЫГ ТОГТООСОН²:

БАЯНХОНГОР АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗРЫН
ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР:  Б.МӨНХБАТ

НОМГОН АУДИТ ХХК-ИЙН
АУДИТОР:  О.МАНДАХ

647743544
БЧ020067 9007423

¹ Захиргааны ерөнхий хуулийн 94 дүгээр зүйлийн 94.1 "Захиргааны актыг энэ хуульд заасан журмын дагуу мэдэгдсэнээс хойш 30 хоногийн дотор гомдлыг хянан шийдвэрлэх захиргааны байгууллагад гаргана."

² Төрийн аудитын тухай хуулийн 16 дугаар зүйлд заасан этгээд, хүчин төгөлдөр болсон албан шаардлага, төлбөрийн актыг хугацаанд нь биелүүлээгүй, аудитын үйл ажиллагаанд саад учруулсан, санхүүгийн тайлангийн аудитаар сөрөг дүгнэлт авсан, хуулиар хориглосон үйл ажиллагаа явуулсан, албан үүргээ биелүүлээгүй, албан тушаалын бүрэн эрхээ хэтрүүлсэн нь аудитаар илэрсэн бол тухайн албан хаагчид сахилгын шийтгэл ногдуулах үндэслэл болно



БАЯНХОНГОР АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР
АКТ

2025 оны 2 сарын 25 өдөр

Дугаар 47/14225456/БНА-2025/187/ Номгон
НА-СТА-ТШЗ

Төлбөр барагдуулах тухай

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлд тодорхойлсон Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд Бууцагаан сумын Цэцэрлэгийн 2024 оны жилийн эцсийн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитаар дараах зөрчил илэрлээ. Үүнд:

Цэцэрлэгийн эрхлэгчийн 2024 оны 11 дүгээр сарын 24 өдрийн "Байгууллагын гүйцэтгэлийн үнэлгээний нэмэлт урамшуулал олгох хуваарь батлах тухай" А/ 20 дугаар тушаалаар олгосон 8,438,200 төгрөгийн нэмэлт урамшууллаас 843,820 /Найман зуун дөчин гурван мянга найман зуун хорин/ төгрөгийн ХХОАТ суутган тооцоо хийгээгүй байна.

Энэ нь ХХОАТ-ын тухай хуулийн 7 дугаар зүйлийн 7.1-Албан татвар төлөгчийн цалин, хөдөлмөрийн хөлс, шагнал, урамшуулал болон тэдгээртэй адилтгах хөдөлмөр эрхлэлтийн орлогод дараах орлогыг хамруулна: мөн 7.1.1.ажил олгогчтой байгуулсан хөдөлмөрийн гэрээнд заасны дагуу авч байгаа үндсэн цалин, нэмэгдэл хөлс, нэмэгдэл, шагнал, урамшуулал, амралтын олговор, тэтгэвэр, тэтгэмж, тэдгээртэй адилтгах бусад орлого; гэсэн заалтыг зөрчиж үнэн ба зөв байх, нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийг хангаагүй байна.

Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.2 дахь "Шалгагдагч этгээд төсөв, санхүү, нягтлан бодох бүртгэлийн үйл ажиллагаа болон төсвийн орлого бүрдүүлэх, зарцуулах, нийтийн өмч, хөрөнгө олж бэлтгэх, ашиглах, зарцуулах, хадгалах, хамгаалахтай холбоотой хууль тогтоомж, захиргааны хэм хэмжээний болон бусад эрх зүйн акт зөрчсөн бол төлбөрийн акт тогтооно", Монгол Улсын Ерөнхий аудиторовын 2020 оны А/95 дугаар тушаалаар баталсан "Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох журам"-ын 4 дүгээр зүйлийн 4.2.3.8 дахь "Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.2-т заасан бусад нөхцөл байдал үүссэн" гэснийг тус тус үндэслэн **ТОГТООХ** нь:

1. Гүйцэтгэлийн үнэлгээний урамшууллаас ХХОАТ-т суутган тооцоогүй 843,820.0 /Найман зуун дөчин гурван мянга найман зуун хорин/ төгрөгийг

5050090

холбогдох ажилтнуудаар төлүүлж төлбөрийг Баянхонгор аймгийн Төрийн сан дахь бусад татвар хураамжийн орлогын 100030000947 тоот дансанд төвлөрүүлэх.

2.Төлбөрийн актыг бүрэн барагдуулж, санхүүгийн баримтыг 2025 оны 05 дугаар сарын 30-ны дотор Баянхонгор аймаг дахь Төрийн аудитын газарт ирүүлэхийг Бууцагаан сумын Цэцэрлэгийн эрхлэгч Д. Гэрлээ, нягтлан бодогч Д.Мөнхтуяа нарт хариуцуулав¹.

ТӨЛБӨРИЙН АКТЫГ ТОГТООСОН²:

БАЯНХОНГОР АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗРЫН
ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР: *[Signature]* **Б.МӨНХБАТ**

НОМГОН АУДИТ ХХК-ИЙН
АУДИТОР: *[Signature]* **О.МАНДАХ**

[Red Stamp: Төрийн сан, Баянхонгор аймгийн төрийн сан, 9717143544, 971400679007423]

¹ Захиргааны ерөнхий хуулийн 94 дүгээр зүйлийн 94.1 "Захиргааны актыг энэ хуульд заасан журмын дагуу мэдэгдсэнээс хойш 30 хоногийн дотор гомдлыг хянан шийдвэрлэх захиргааны байгууллагад гаргана."

² Төрийн аудитын тухай хуулийн 16 дугаар зүйлд заасан этгээд, хүчин төгөлдөр болсон албан шаардлага, төлбөрийн актыг хугацаанд нь биелүүлээгүй, аудитын үйл ажиллагаанд саад учруулсан, санхүүгийн тайлангийн аудитаар сөрөг дүгнэлт авсан, хуулиар хориглосон үйл ажиллагаа явуулсан, албан үүргээ биелүүлээгүй, албан тушаалын бүрэн эрхээ хэтрүүлсэн нь аудитаар илэрсэн бол тухайн албан хаагчид сахилгын шийтгэл ногдуулах үндэслэл болно



БАЯНХОНГОР АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР
АЛБАН ШААРДЛАГА

2025 оны 02 сарын 25 өдөр

Дугаар 121/14225456/БНА-2025/181/Монгол
НА-СТА-ТШЗ

Зөрчил арилгуулах тухай

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлд тодорхойлсон Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд Бууцагаан сумын Цэцэрлэгийн 2024 оны жилийн эцсийн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитаар дараах зөрчил илэрлээ. Үүнд:

Цэцэрлэгийн хүүхдийн хоолны материал нийлүүлэх тендерт шалгарч гэрээ байгуулсан “Үүрээр цацрах гэгээ ХХК” нь хүнсний материалыг 3,573,043 /Гурван сая таван зуун далан гурван мянга дөчин гурван/ төгрөгийн үнийн зөрүүтэй нийлүүлсэн байна.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.1 “төсвийг үр ашигтай хэмнэлттэй байхаар төлөвлөж зарцуулах” заалт, Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил үйлчилгээ, худалдан авах тухай хуулийн 39 дүгээр зүйлийн 39.3.1 дах “гэрээний үнэ” заалтыг зөрчсөн, “Нийцсэн бөгөөд зохистой байх” гэсэн батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.1 дэх “Шалгагдагч этгээд хууль тогтоомж, захиргааны хэм хэмжээний болон бусад эрх зүйн акт зөрчсөн, хуулиар хүлээсэн албан үүргээ биелүүлээгүй бол алдаа, зөрчлийг таслан зогсоох, давтан гаргуулахгүй байх талаар байгууллага, албан тушаалтанд албан шаардлага өгнө”, Монгол Улсын Ерөнхий аудиторын 2020 оны А/95 дугаар тушаалаар баталсан “Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох журам”-ын 4 дүгээр зүйлийн 4.2.1.11 дахь “хууль тогтоомж, гэрээ, хэлцэл зөрчсөн алдаа, зөрчлийг таслан зогсоож, давтан гаргуулахгүй байх үр нөлөөтэй гэж үзсэн бусад нөхцөл байдал” гэснийг тус тус үндэслэн **ШААРДАХ нь:**

1.Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил үйлчилгээ, худалдаан авах тухай хуулийн хэрэгжилтийн ханган гэрээний үнийг мөрдөж

5040236

төсвийг үр ашигтай зарцуулах, зөрчлийг арилган биелэлтийг 2025 оны 05 дугаар сарын 30-ны дотор Баянхонгор аймаг дахь Төрийн аудитын газарт ирүүлэх¹.

2.Цаашид алдаа, зөрчлийг давтан гаргахгүй байх, хууль тогтоомжийг хэрэгжүүлж ажиллахыг Бууцагаан сумын Цэцэрлэгийн эрхлэгч Д. Гэрлээ, нягтлан бодогч Д. Мөнхтуяа нарт даалгав².

АЛБАН ШААРДЛАГЫГ ӨГСӨН³:

БАЯНХОНГОР АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗРЫН
ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР: *Б.Мөнхбат* Б.МӨНХБАТ

НОМГОН АУДИТ ХХК-ИЙН
АУДИТОР: *О.Мандах* О.МАНДАХ

6450743544
54740067 9007423

¹ Монгол Улс, Баянхонгор аймаг, Баянхонгор сум, Нутгийн удирдлагын ордон 3 давхар

² Захиргааны ерөнхий хуулийн 94 дүгээр зүйлийн 94.1 "Захиргааны актыг энэ хуульд заасан журмын дагуу мэдэгдсэнээс хойш 30 хоногийн дотор гомдлыг хянан шийдвэрлэх захиргааны байгууллагад гаргана."

³ Төрийн аудитын тухай хуулийн 42.1-т энэ хуулийн 16 дугаар зүйлд заасан этгээд, хүчин төгөлдөр болсон албан шаардлага, төлбөрийн актыг хугацаанд нь биелүүлээгүй, аудитын үйл ажиллагаанд саад учруулсан, санхүүгийн тайлангийн аудитаар сөрөг дүгнэлт авсан, хуулиар хориглосон үйл ажиллагаа явуулсан, албан үүргээ биелүүлээгүй, албан тушаалын бүрэн эрхээ хэтрүүлсэн нь аудитаар илэрсэн бол тухайн албан хаагчид сахилгын шийтгэл ногдуулах үндэслэл болно



БАЯНХОНГОР АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР
АЛБАН ШААРДЛАГА

2025 оны 02 сарын 25 өдөр

Дугаар 119/14225456/БНА-2025/181 Номгон
НА-СТА-7ШЗ

Зөрчил арилгуулах тухай

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлд тодорхойлсон Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд Бууцагаан сумын Цэцэрлэгийн 2024 оны жилийн эцсийн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитаар дараах зөрчил илэрлээ. Үүнд:

Боловсролын байгууллагын онцлогоос шалтгаалж 2024 оны 6 дугаар сард олгосон ээлжийн амралтын мөнгийг нийгмийн даатгалын мэдээнд 6-8 саруудад мэдээлэхдээ 4 ажилтны цалингаас суутган тооцсон нийгмийн даатгалын шимтгэлийн өглөг 1,049,024.18 /Нэг сая дөчин есөн мянга хорин дөрвөн төгрөг арван найман мөнгө/, ХХАОТ-ын өглөг 257,868.5/ хоёр зуун тавин долоон мянга, найман зуун жаран найман төгрөг тавин мөнгө/ нийт 1,306,892.68/ Нэг сая гурван зуун зургаан мянга найман зуун ерэн хоёр төгрөг жаран найман мөнгө/ төгрөгийн өглөгийг нягтлан бодох бүртгэлд бүртгээгүй, нийгмийн даатгалын шимтгэлийн мэдээ, татварын мэдээнд тайлагнаагүй байна.

Дээрх зөрчил нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.1" Анхан шатны баримт нь нягтлан бодох бүртгэл хөтлөх, санхүүгийн тайлан, мэдээллийг үнэн, зөв гаргах үндэслэл болно", мөн 20 дугаар зүйлийн 20.2.5."дансны өглөг, авлага ба төлбөрийн тооцоог хянах, ажил, гүйлгээг гарахаас нь өмнө хянан, баталгаажуулах", Нийгмийн даатгалын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.1."Ажил олгогч даатгуулагчийн цалин хөлс, түүнтэй адилтгах орлогоос нийгмийн даатгалын шимтгэлийг сар бүр тооцон суутгаж, ажил олгогчийн цалин хөлсний сан, түүнтэй адилтгах орлогоос тооцсон шимтгэлийн хамт тухайн сард багтаан нийгмийн даатгалын санд төлнө", ХХАОТ-ын тухай хуулийн 7 дугаар зүйлийн 7.1-д "Албан татвар төлөгчийн цалин, хөдөлмөрийн хөлс, шагнал, урамшуулал болон тэдгээртэй адилтгах хөдөлмөр эрхлэлтийн орлогод дараах орлогыг хамруулна", 7.1.1-д "ажил олгогчтой байгуулсан хөдөлмөрийн гэрээнд заасны дагуу авч байгаа үндсэн цалин, нэмэгдэл хөлс, нэмэгдэл, шагнал,

5040225

урамшуулал, амралтын олговор, тэтгэвэр, тэтгэмж, тэдгээртэй адилтгах бусад орлого;" гэсэн заалтуудыг зөрчиж, "Нийцсэн бөгөөд зохистой байх" гэсэн батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.1 дэх "Шалгагдагч этгээд хууль тогтоомж, захиргааны хэм хэмжээний болон бусад эрх зүйн акт зөрчсөн, хуулиар хүлээсэн албан үүргээ биелүүлээгүй бол алдаа, зөрчлийг таслан зогсоох, давтан гаргуулахгүй байх талаар байгууллага, албан тушаалтанд албан шаардлага өгнө", Монгол Улсын Ерөнхий аудиторовын 2020 оны А/95 дугаар тушаалаар баталсан "Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох журам"-ын 4 дүгээр зүйлийн 4.2.1.11 дахь "хууль тогтоомж, гэрээ, хэлцэл зөрчсөн алдаа, зөрчлийг таслан зогсоож, давтан гаргуулахгүй байх үр нөлөөтэй гэж үзсэн бусад нөхцөл байдал" гэснийг тус тус үндэслэн **ШААРДАХ нь:**

1.ХХОАТ-ын тайлан, Нийгмийн даатгалын шимтгэлийн тайланд 4 ажилтны цалинг нөхөн мэдээлж, зөрчлийг арилган биелэлтийг 2025 оны 05 дугаар сарын 30-ны дотор Баянхонгор аймаг дахь Төрийн аудитын газарт ирүүлэх¹.

2.Цаашид алдаа, зөрчлийг давтан гаргахгүй байх, хууль тогтоомжийг хэрэгжүүлж ажиллахыг Бууцагаан сумын Цэцэрлэгийн эрхлэгч Д.Гэрлээ, нягтлан бодогч Д. Мөнхтуяа нарт даалгав².

АЛБАН ШААРДЛАГЫГ ӨГСӨН³:

БАЯНХОНГОР АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗРЫН ДАРГА,
ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР: **Б.МӨНХБАТ**

НОМГОН АУДИТ ХХК-ИЙН
АУДИТОР **О.МАНДАХ**

6317143544
БҮӨА0067 9007423

¹ Монгол Улс, Баянхонгор аймаг, Баянхонгор сум, Нутгийн удирдлагын ордон 3 давхар

² Захиргааны ерөнхий хуулийн 94 дүгээр зүйлийн 94.1 "Захиргааны актыг энэ хуульд заасан журмын дагуу мэдэгдсэнээс хойш 30 хоногийн дотор гомдлыг хянан шийдвэрлэх захиргааны байгууллагад гаргана."

³ Төрийн аудитын тухай хуулийн 42.1-т энэ хуулийн 16 дугаар зүйлд заасан этгээд, хүчин төгөлдөр болсон албан шаардлага, төлбөрийн актыг хугацаанд нь биелүүлээгүй, аудитын үйл ажиллагаанд саад учруулсан, санхүүгийн тайлангийн аудитаар сөрөг дүгнэлт авсан, хуулиар хориглосон үйл ажиллагаа явуулсан, албан үүргээ биелүүлээгүй, албан тушаалын бүрэн эрхээ хэтрүүлсэн нь аудитаар илэрсэн бол тухайн албан хаагчид сахилгын шийтгэл ногдуулах үндэслэл болно



БАЯНХОНГОР АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР
АЛБАН ШААРДЛАГА

2025 оны 02 сарын 25 өдөр

Дугаар 119/14225456/БНА-2025/181/Номгон
НА-СТА-ТШЗ

Зөрчил арилгуулах тухай

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлд тодорхойлсон Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд Бууцагаан сумын Цэцэрлэгийн 2024 оны жилийн эцсийн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитаар дараах зөрчил илэрлээ. Үүнд:

Боловсрол Шинжлэх ухааны яамны 2024 оны 06 дугаар сарын 24-ны өдрийн 2/2772 дугаар албан бичгийг үндэслэн аймгийн Боловсролын газрын даргын 2024 оны 07 дугаар сарын 09-ний өдрийн “Урамшуулал олгох тухай” Б/42 дугаар тушаалаар төсвийн шууд захирагчид балансын урамшуулал нэг сарын цалинтай тэнцэх 1,544,000 (Нэг сая таван зуун дөчин дөрвөн мянга) төгрөгийн урамшуулал олгосон байна.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 6,4,1 төсвийг үр ашигтай хэмнэлттэй байхаар төлөвлөж зарцуулах, Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 23 дугаар зүйлийн 23.2-т “Нягтлан бодох бүртгэлийн ажилд үр бүтээл гарган ажилласан нягтлан бодох бүртгэлийн ажилтныг шагнаж урамшуулж болно” гэсэн заалтыг зөрчсөн, “Нийцсэн бөгөөд зохистой байх” гэсэн батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.1 дэх “Шалгагдагч этгээд хууль тогтоомж, захиргааны хэм хэмжээний болон бусад эрх зүйн акт зөрчсөн, хуулиар хүлээсэн албан үүргээ биелүүлээгүй бол алдаа, зөрчлийг таслан зогсоох, давтан гаргуулахгүй байх талаар байгууллага, албан тушаалтанд албан шаардлага өгнө”, Монгол Улсын Ерөнхий аудиторовын 2020 оны А/95 дугаар тушаалаар баталсан “Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох журам”-ын 4 дүгээр зүйлийн 4.2.1.11 дахь “хууль тогтоомж, гэрээ, хэлцэл зөрчсөн алдаа, зөрчлийг таслан зогсоож, давтан гаргуулахгүй байх үр нөлөөтэй гэж үзсэн бусад нөхцөл байдал” гэснийг тус тус үндэслэн **ШААРДАХ нь:**


5040230

1.Төсвийн шууд захирагч нарт балансын урамшуулал олгодог байдлыг таслан зогсоох , зөрчлийг арилган биелэлтийг 2025 оны 05 дугаар сарын 30-ны дотор Баянхонгор аймаг дахь Төрийн аудитын газарт ирүүлэх¹.

2.Цаашид алдаа, зөрчлийг давтан гаргахгүй байх, хууль тогтоомжийг хэрэгжүүлж ажиллахыг Бууцагаан сумын Цэцэрлэгийн эрхлэгч Д. Гэрлээ, нягтлан бодогч Д.Мөнхтуяа нарт даалгав².

АЛБАН ШААРДЛАГЫГ ӨГСӨЙ³:

БАЯНХОНГОР АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗРЫН
ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР:  Б.МӨНХБАТ

НОМГОН АУДИТ ХХК-ИЙН
АУДИТОР:  О.МАНДАХ



¹ Монгол Улс, Баянхонгор аймаг, Баянхонгор сум, Нутгийн удирдлагын ордон 3 давхар

² Захиргааны ерөнхий хуулийн 94 дүгээр зүйлийн 94.1 "Захиргааны актыг энэ хуульд заасан журмын дагуу мэдэгдсэнээс хойш 30 хоногийн дотор гомдлыг хянан шийдвэрлэх захиргааны байгууллагад гаргана."

³ Төрийн аудитын тухай хуулийн 42.1-т энэ хуулийн 16 дугаар зүйлд заасан этгээд, хүчин төгөлдөр болсон албан шаардлага, төлбөрийн актыг хугацаанд нь биелүүлээгүй, аудитын үйл ажиллагаанд саад учруулсан, санхүүгийн тайлангийн аудитаар сөрөг дүгнэлт авсан, хуулиар хориглосон үйл ажиллагаа явуулсан, албан үүргээ биелүүлээгүй, албан тушаалын бүрэн эрхээ хэтрүүлсэн нь аудитаар илэрсэн бол тухайн албан хаагчид сахилгын шийтгэл ногдуулах үндэслэл болно